

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2015 оны 05-р сарын 01-ний өдөр

Гэрээний нэр, дугаар: АХО-2015-2

Төслийн нэр, дугаар: Гэрээт харуул хамгаалалтын үйлчилгээ

“Монголросцветмет” ХХК нь эрх бүхий тендерт оролцогчдыг “Гэрээт харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх” тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь **50000** төгрөгөөр худалдан авч болно.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

- **Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жилд хийж гүйцэтгэсэн ажлын аль нэг жилийн борлуулалтын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.
- **Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх
- **Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 2 жил
- **Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Сүүлийн 3 жилийн аль нэг жилд санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй үйлчилгээг гүйцэтгэсэн байх. /Нотлох баримт болгож гэрээ болон гэрээ дүгнэсэн актын хуулбарыг хавсаргаж ирүүлнэ./

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байх ба тендерийн үнийн дүнгийн 2 хувьтай тэнцэх дүнтэй тендерийн баталгаатай хамт ирүүлнэ.

Тендерийг 2015 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 16:00 цагаас өмнө “Монголросцветмет” ХХК-ийн тендерийн комисст” гэж хаяглан Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Энхтайваны гудамж 98, Монголросцветмет ХХК-ийн байр, өрөө 402 тоот хаягаар ирүүлэх бөгөөд тендерийг 2015 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 16:30 цагт тус компанийн 2 давхар дахь уулзалтын танхимд уг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан нээнэ.

Гадаадын этгээд оролцох эрхгүй.

Давуу эрх олгохгүй.

**Хаяг: Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 98,
“Монголросцветмет” ХХК-ийн байр, 402 тоот өрөө,
утас: 450060-112, факс: 458380 шуудангийн хаяг: Улаанбаатар 51, ш/х- 002**

МОНГОЛРОСЦВЕТМЕТ ХХК